

ОЙРХИ ДОРНОДЫГ ЭЗЭГНЭЖ ЯВСАН ОЙРАД МОНГОЛ СУЛТААНАА БИД ХЭР МЭДДЭГ БИЛЭЭ?

*Б.Баасансүрэн**

Монголчууд Ил хааны улсын үед буюу 1250-иад оны үед Ойрхи Дорнодын Ирак, Иорданаар тогтохгүй цаашлаад хойд Африкт хүрч Египет, Сирийн төр барих хэрэгт оролцож явсан байх юм. Арабын эх сурвалжууд болон эл чиглэлээр судалгаа хийсэн Өрнөдийн эрдэмтдийн судалгаа бүтээлүүдээс үзвэл Ил хааны монгол улсын харъяаны цөөнгүй монголчууд ийнхүү Араб ертөнцийг эрх барих хэрэгт нэрээ үлдээсэн байна. Ойрад монголын ноёд өрх гэрээрээ 13 дугаар зууны сүүлээр Сири, Египетэд хүрч очиж байсан төдийгүй Мамлюкийн Анхдугаар улсын төрийн хэрэгт оролцож, чамгүй үүрэг гүйцэтгэж байсан нэн сонин агаад үнэн түүхийг монголчууд бид сайн мэдэхгүй өдий хүрсэн бололтой. Үүний нэг нь Хэтбух хэмээх ойрад монгол мөн болой.

Иран, Ирак, Афганистан, Төв Азийн өргөн уудам нутгийг эзэгнэсэн Ил хааны монгол улсын цэргийн эрхтнүүдийн дотор цөөнгүй ойрадууд байжээ. Ил хааны цэрэг Ирактай хил залгаа Туркийг мэдэлдээ авч Сири, Иордан, Палестинд хагас хяналтаа тогтоон, дагаар орохыг Египетэд тулган, үе үе уулаглан довтолж, армитай нь тулж, дайны байдалтай 50 гаруй жил явж ирсэн байдаг.

1260 онд Сирийн нутаг Хомст Ил хааны багахан хэмжээний цэргийнхэнтэй хийсэн тулгаралтын үеэр Египетийн цэрэгт цөөнгүй монгол цэрэг олзлогдсоны дотор Хэтбух гэж ойрад байжээ.

Тэрээр суллагдан, египетийн армид алба хааж явсаар төдөлгүй дунд тушаалын офицер - эмир болсон байдаг. Тэрээр эзэн хаанд үнэнчээр зүгэсний учир эрэлхэг зоригт Заин аль-Хэтбуга (al-Din Kitbugha) аль-Мансури гэдэг гуншин авч дэвшиж явсаар Египетийн хаан хөвгүүн Насер Мухаммад Калауны баруун гар нь болж чадсан юм.

Өөрөөс нь өрсөж хаан ширээ авах гээд байсан черкесс эмирыг Хэтбух хөнөөж, 10 гаруйхан настай Насер хүүгээс Египет-Сирийн засгийн эрхийг 1294 онд эв зүй, энхийн аргаар авсан болой.¹ Хаан ширээнд суухдаа Аль-Малик аль-Адил цол хэргэм авч байж. Ийнхүү баруун монголын хийморилог, дайчин ойрад Араб ертөнцийн эзэн болж хаан ширээнд залрах нь тэр.

Султант улсын төрийг 2 жил барих хугацаандаа тэрээр нутаг нэгт монголчууддаа их анхаарсан байдаг. 1294 оны сүүлээр 100 гаруй ойрад өрх гэрээрээ ирсэн бөгөөд удаах жил нь буюу 1295 оны сүүлээр зэргэлдээх Ил хааны улсаас Ойрадын монголын томоохон бүлэг цагаачлан орж ирсэн² байдаг.

* Б.Баасансүрэн - Монгол Улсаас Египетэд суугаа ЭСЯ-ны зөвлөх

Персийн монгол хаан-Махмуд Газан лалын шашинд орж бусад шүтлэгтүүдийг шахан хавчих болсны улмаас гадгаш дүрвэгсэд ихэсчээ. Ил хааны монгол улсын иргэдийн тал нь бурханы шашинтан, нестрион шүтлэгтэн хийгээд атеистууд байсан ба тэдний зарим нь Газаны шийдвэрээс дайжин гадагш ийнхүү зугтан гарч байж. Зарим мэдээгээр 10 гаруй мянган ойрад монголчууд өрх гэрээрээ мал хөрөнгөө авч орж ирсэн мэт байдаг. Тэднийг тэнгэрт хальсан Хүлэг хаан агсаны хүргэн Турхай\Төрөө (Torghay) тэргүүлж ирсэн³ гэсэн мэдээ үлдсэн байна. Авгай хүүхдээ дагуулан өрх гэрээрээ мал сүргээ авч ирсэн тэдгээр монголчуудыг Хэтбух хаан талархан угтсанаас гадна шинэ газарт түргэн төвхнөж суурьшихад зориулж мөнгө төгрөг өгч санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ажээ. Зарим судлаачдын бичснээр тэд бүр Төв Азиас тухайлбал, баруун Монголоос дайсагнасан олон орныг дамжин амь насаараа дэнчин тавин байж ирсэн хүмүүс их байсан гэх нь бас бий.

Тэдний дийлэнх нь атеистууд (шашны харьяалалгүй байсан) байж, лалын ёс жаягт нь тоомжиргүй хандаж байсан болохоор сири, египетчүүд нэг их талтай биш байж, Хэтбухын энэхүү алхамд дотроо дургүй байв.

Үүнийг гадарласан хааны ордныхон тэдний олонхийг нь Ливан, Израилийн өмнөд хэсгийн Аль-Бига (Al-Biqa), Гагун (Qaqun) Сирийн тэнгисийн эрэг орчмын зах хязгаарт хүргүүлж, нутгийнхны дунд оруулж хольж суурьшуулсан гэх. Чингэхдээ, загалмайтнуудын довтлон орж ирдэг угтал газруудад жийргэвч болгон суурьшуулсан⁴ бололтой байдаг. Эрэлхэг зоригтой атлаа нэлээд зэрлэг бүдүүлэг эдгээр иргэдийг⁵ ийнхүү суурьшуулснаар лалын шашинд оруулах⁶ хялбар арга сэдсэн гэж арабын түүхийн сурвалж бичгүүдэд өгүүлжээ.

Зарим мэдээгээр Персээс ирсэн монголчуудаас зөвхөн 300 морьт цэрэг л авсан гэх ба дээр дурдсан тэр олныг (10 мянган орчим) бүгдийг нь оруулж суурьшуулах техникийн нөхцөл боломж тухайн үед үгүй байсан гэх мэдээ байх ба энэ нь үнэнд дөхүүтэй⁷ байх.

Тэднээс бие бялдар, царай зүсээр нь шилж 300 элитийг нь Египетэд авчирч, хааны ордны албанд нэлээдийг нь авч үлдсэн хэсгийг нь Каирын дэргэдэх Ситадел дэх цэргийн хуаран, ангиудад хуваарлан, үлдснийг нь Хуссейна дүүрэгт суурьшуулсан⁸ тухай мэдээ бий.

Ойрадуудыг ийнхүү талархан угтах болсон нь Султаан Хэтбух өөрөө ойрад байснаас гадна улс төрийн учир шалтгаан байсан. Түүнийг албан тушаалаас нь зайлуулах гэсэн эмир Хасам, Лачин нарын зэрэг дотоодын улс төрийн олон хүчний өөдөөс нутаг нэгтнүүддээ түшиглэн байр сууриа бататган авч, төрийн хэргээ тухтай явуулах зорилго агуулж байжээ.

Тэд лал бус, “буруу номын” улс, тэрс шашинтан байсан хэдий ч хүүхнүүд нь үзэсгэлэн төгөлдөр байсны учир Мамлюкийн эмирууд,

хааны ордоньхон богтолж, эхнэр болгох авцгаасан гэх. Тэд ийнхүү султант улсын дээдсийн хүрээнийхэнтэй цус холилдож ураг төрөл болсон байдаг.

Хэтбухын үед монголчуудтай цус холилдсон гэр бүл бүр ихэссэн. Чингээд анх монголчуудыг Египетэд зааж өгч суурьшуулж байсан Өнөөгийн (Египетийн нийслэл) Каирын зүрхэн тус газар буюу тэр үеийн Хуссейна, Баб эл Лоук дүүрэгт бол бүр илүүтэй байжээ. Нутгийнхан монгол бүсгүйчүүдийн царайлагт нь татагдан сууж гэрлэх нь илүүтэй байж.

Гэтэл лал бус-буруу номтон, сүсэг бишрэлгүй энэ ойрад монголчуудад улс төрийн их боломж олголоо хэмээн Хэтбухтай өрсөлдөгч эрх баригчид төдийгүй олон нийтийн дунд дургүйцэл, жийрхэл газар авсаар байж. Үүнийг нь далимдуулан дэд султаан Лачин 1296 онд ордны эргэлт хийж, Хэтбухыг огцруулсан.

Лачин хаан болмогцоо хаан ордон дахь монголчуудын нөлөөг сулруулах, Египетээс монголчуудыг хүчээр гаргах гэж нэлээд үзсэн байдаг. 1296 онд Лачин өөрийн хүмүүсээр Ойрад монголын цөөнгүй ноёдыг баривчлан Египетийн умарт боомт Александр хотод хүргүүлж, шоронд хорьж байгаад удалгүй амийг нь хөнөөсөн гэж Каирын их сургуулийн түүхий ухааны доктор Салих Ад-Дин Нуор бичсэн байдаг. Тухайлбал хааны ордонд их нөлөөтэй байсан ойрадын гол 3 эмир-Турхай (Taraghai), Хөхтэй (Kaktay), Улс (Ulus) нарыг баривчилсан⁹ гэх бөгөөд тэдний хувь заяа нь тодорхойгүй үлджээ. Ойрад албатуудыг нь эрх баригч- эмирүүдэд тараан өгч алс газруудад цацаж уугуул иргэдтэй хольж уусгав¹⁰ гэсэн мэдээ ч таарч байна.

Гэхдээ Ойрд монголчууд дийлдэж бууж өгөлгүй эцсээ дуустал үзэлцээр байсныг гэрчлэх баримт байна. Тэд Египетийн цэргийнхний дунд болон дээгүүр хүрээн дэх нөлөөлөлдөө дулдуйдан Хэтбухыг хаан ширээнд нь эгүүлэн залах нууц хуйвалдаан хэдэнтээ зохион байгуулж байгаад тэр нь дараалан бүтэлгүйтэж байж. Тухайлбал 1299 онд Байбарсын ханхүү хоёрдугаар Жасэнкер (Jashenkeer), болон ордонд хоёрдугаар хүн болоод байсан Сэйф ад-Дин Салар (Seif ad-Din Salar) нарыг Палестинд байхад нь тэдгээрийг барьж цааш харуулах гэсэн ойрадуудын энэ хуйвалдаан нь илэрч олон оролцогч дүүжлүүлсэн¹¹ гэх. Эл бослогыг тухайн үедээ хааны ордонд тодорхой нөлөөтэй байсан эмир Улс (Ulus) нарын ойрад түшмэд голчлон зохион байгуулсан бөгөөд хүчин мөхөсдөж бүгд баригдаж цаазлуулжээ. Гэхдээ эмир Улс энэ удаад эсэн мэнд гарч дараа жил нь Султааны торгон цэрэг Боролдой (Saif ad-Din Buriltay) Хөтөлбарс (Qutulubars al-Adili) нарын хамтаар дахин босож, төр эргүүлэн, Хэтбухыг сэргээн залах гэж тэмцсэн боловч төдөлгүй дарагдаж цаазлуулсан¹² байх ажгуу.

Хүний нутагт эрчүүдийнхээ нэгэн адил ойрад эмэгтэйчүүд ч гэсэн улс төрийн хэрэгт гар бие оролцож, эрэлхэг дайчин явсан бөгөөд төрийн эргэлт хийх дээрх хуйвалдаан, нууц ажиллагаанд ойрад хатад гар бие оролцож байсан нь Египетийн түүхийн эх сурвалж бичгүүдэд нотлох баримт, мэдээ сэлт болон үлдсэн¹³ байх ажгуу.

2 жилийн дараа Лачин өөрөө ордны эргэлтэд өртөж амиа алдсан. Насер Калаун Лачинг барьж цаазлан, хаан ширээнд гарч ирэхэд нь ойрадуудын оролцоо багагүй байсан гэнэ. Энэ утгаараа шинэ тутам султан Калаунд ойрадууд ямар нэг хэмжээгээр найдлага тавьж байсан нь талаар болсон бололтой юм.

Калаун засгийн эрхийг авмагцаа бусдын дарамтад автан ойрадуудад олигтой нүүр өгсөнгүй, хавчих хязгаарлах бодлого ямар нэг хэмжээгээр үргэлжилсэн хэвээр байсан бололтой байдаг.

Ойрхи Дорноддоо их гүрэн болоод байсан Египетийн эзэн буюу мамлюктийн анхдугаар улсын султан явсан Хэтбух хаан ширээнээс зайлуулагдснаасаа хойш Египет, Сирийн Сархад (Sarkhad) дараа нь Хамаах (Hamah) зэрэг мужуудын захирагчийн ажил хийж байгаад 1303 онд насан өөд болжээ.

Хэтбух агуу монгол байсныг нь гэрчлэх олон баримт үлдсэн байна. Каирт хаан болохоос өмнө сууж байсан байрныхаа дэргэд морины том хашаатай, олон адуутай, моринд дуртай жинхэнэ монгол хүн байжээ.

Султанаар залрах богино хугацаандаа тэрээр Каирт сургууль, мөргөлийн том цогцолборыг 1295 онд эхлүүлсэн байх бөгөөд түүний удаах султан Мухаммад Насер султан зарлигдан уг барилгыг 1305 оны эхээр дуусгуулсан болой. “Насер султаны сургууль, бунхны цогцолбор” гэгдэх энэ ордон нь Энэтхэгийн Таж Махалын удаад орох гоёмсог ур хийцтэй бөгөөд өнөөдөр Каирт ирсэн гадаадын жуулчдын зайлбаргүй очиж үзэх дуртай түүх дурсгалын ховор үзмэрийн нэгд зүй ёсоор орж байна.

Бүр хожим 1305 онд 200 морьтон ойрад нэмж ирсний дотор Египетийн дэд султан ойрад Саларын ээж, 2 дүү нь байсан¹⁴ гэнэ. Хамаатан, үр хүүхэд нь алсын Африк тивийн хойд хэсэгт - мамлюкийн султант улсад эсэн мэнд байгаа сургийг нь гаргасан ах дүү ээж аав нар нь бараг 30 шахам жилийн дараа хэл ам авалцан баруун Монголоос ийнхүү зорьж очиж байсан нь үнэхээр гайхмаар.

Египетэд Ойрад монголчууд үлдэн хоцорч хожуу ч гэсэн байсаар байсны нэг жишээ бол, Султан Насер Калауны торгон цэрэг ойрд монгол – Сейф ад-Дин Алмасаар түүхч Макрийзи жишээ татсан байгаа юм. Тэрээр бичихдээ, “Сейф Алмас нь Амий гэдэг монгол сүйт бүсгүйтэй байсан. Түүнтэйгээ болзсон ёсоороо уулзах гээд очтол нөгөөх нь /1333 онд/ амиа алдсан байсан” гэжээ.

Ойрад монгол бүсгүйчүүд Египетийн төрийг угсаруулан /ээлжлэн/ 60 шахам жил барьсан Бибарс, Калаун, Хэтбуга, Насер гэх дөрвөн султааны хатад байсан үнэмшихэд бэрхтэй ч үнэн түүх бас байна. Энэ утгаараа, эдгээр султаадын хадам эцэг нь Хармөнх, Сүхтэй, Цэнгэл зэрэг Ойрад ноёд байсан тухай түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн үлджээ. Тухайлбал, 17 жил султаан асан Бибарсын дунд хатан нь Сейф ал-Дин Кармун (Sayf al-Din Karamun al-tatari) гэгч ойрадаас орж ирсэн цэргийн эрхтэн Хармөнх\Хэрмэнхийн охин байжээ.

Бибарсын удаагаар 10 гаруй жил мамлюкийн султантыг хаанчилсан Аль-Малик аль-Мансур Калавун олон эхнэртэй байсан нэгэн. Тэрээр Сүхтэй, Хармөнх зэрэг ойрадоос ирсэн монголын цэргийн эрхтэнүүдийн хүргэн байсан.¹⁵ Хармөнхийн том охинтой сууж байгаад, түүнийг нас нөхчихөөр нь дүүг нь авч суусан байдаг.¹⁶ Аль-Малик аль-Мансур Калавун угсаа залгамжилсан Хүү Насер Мухаммад мөн Цэнгэл гэгч монгол эмирийн охиныг богтож эхнэрээ авсан байх жишээтэй.

800 жилийн гэртээд Хойд Африк, Ойрхи Дорнодыг нэг хэсэгтээ доргиож явсан ойрадын цоглог дайчин, эрэлхэг хөвгүүд, охид - баатрууд маань цагийн эрхээр бүгд лалжиж, уусан арабжиж, бүдгэрсээр сураг нь алдарсан бололтой. Өнөөгийн Ливан, Сирийн боомт газруудад болон Египетэд элэнц ойрад аваргуудын маань удам угсаа, генийг нь тээсэн арабууд байхыг үгүйсгэхгүй.

Төмөрдаш, Амар, Бадара гэсэн монгол нэртэй арабууд Египет, Сирид цөөнгүй тааралдах бөгөөд тэдний нэг байх ч юм билүү.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Ibn kathir, 13:338-339, Safadi, A`yan al-`asr, MS.aya Sofiya 2967, fol.47 a; ibn Taghri birdi, 8:55. but cf.Nuwayri MS.2m. fol.132 a; Ibn al-Suqa I, 131, түүнийг Айн Жалугад баривчилсан гэж тэр хэлсэн.
2. Ayalon, the Wafidiya in the Mamluk Kindom. Islamic Culture 25 (1951):89-104 Studies of the Mamluks, vol II
3. *Salah Eddin Mohammed Noar, "Mongol Factions in Egypt and Their Military, Political, Social, Linguistic, & Urban Influence during the Bahriya (Bahri) Mamluk Dynasty from 658 to 783 Hijri (1260-1381 AD) in arabic language.*
4. Abu al-fida, IV. p33. l.19.
5. Khitat, II, p23, 11, 14-15.
6. Мөн тэнд.
7. Мөн тэнд, Reuven Amitai, Mamluks of Mongol Origin and Their role in Early mamluk political life. Mamluk studies review vol.12. no1, 2008, p.135
8. Sulug2
9. Nakamichi Notutaka, a reconsideration of the Wafidiyah, MRS vol.10.no 1.2006, pp69.
10. Salih ad-Din Noar
11. Мөн тэнд.3
12. Al-Nuwayri, Nihayah, 31;381; Ibn al-dawadari, kanz,9:15, al-maqrizi, Suluk, 1:883; Nakamichi Notutaka, a reconsideration of the Wafidiyah, MRS vol.10.no 1.2006, pp80.
13. Salih Nour
14. Reuven Amitai, Mamluks of Mongol Origin and Their role in Early mamluk political life. Mamluk studies review vol.12.no1,2008, p.132
15. Ibn al-Furat. Ta`rikh.VII,125: Maqrizi,Suluk,1,3
16. Maqrizi,Suluk,1,2.542, Linda Northrup,*From slave to Sultan*,116